



E-NEWSLETTER

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САМБАР

Зургаадугаар сар 2017 он

МОНГОЛ УЛСЫН ДОТООДДОО УГСАРСАН АЧААНЫ ВАГОНД ДУГААР ОЛГОЛОО

Монгол Улсад анх удаа “УБТЗ” ХНН-ийн Зүүнхараа вагон засварын депод шинээр угсарч үйлдвэрлэсэн 5 хагас вагон, 2 тавцант вагонд дугаар олгож, шинэ вагоныг ашиглалтад хүлээн авах нээлтийн ажиллагаа, туршилтын аялалд төвийн захирал Т.Ариунбаатар, ахлах мэргэжилтэн Ц.Оюунбат нар оролцсон. Мөн Төмөр замын ачааны вагоны дугаарлалтад тавих шаардлага MNS 6630-2:2016” стандартыг үндэслэн “Эко mogul” ХХК-д “05” тоот өмчлөгчийн кодыг, тус компанийн эзэмшлийн 5 цистерн вагонд шинээр дугаар олголоо.



ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ДҮРЭМ, ЖУРМЫГ ЗАХИРГААНЫЕРӨНХИЙХУУЛЬДНИЙЦҮҮЛЭНШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАВ

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017-оны 16 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс боловсруулсан “Хатуу тооцоот багаж, хэрэгслийг ашиглах болон хүлээлцэх журам”, “Суурь бүтэц ашиглуулах журам”, “Аюултай байгууламж байрлуулах зай, огтлолцлын болон байршлын нөхцөлийг тодорхойлох журам”, “Төмөр замын гарам ашиглах журам” зэрэг нэр бүхий 4 журмын төслүүд, түүнд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналууд (эх болон хуулбар хувь), журмын төсөл хэлэлцсэн хурлын тэмдэглэлүүд, төслийн танилцуулга, сайдын тушаалын төсөл зэрэг баримт бичгийг бүрдүүлэн ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т хүлээлгэн өгсөн.

СУУРЬ БҮТЭЦ ДЭХ ӨВЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ЗУРМАГИЙН ГҮЙЦЭТГЭЛД ШИНЖИЛГЭЭ ХИЙН АЖИЛЛАГАА

Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журмын 6.1-д заасны дагуу хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлийг сайжруулах, суурь бүтцийн тээх нэвтрүүлэх чадвар, суурь бүтэц эзэмшигчийн хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтад хяналт тавих зорилгоор суурь бүтэц дэх өвлийн хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийсэн. Шинжилгээг “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК-уудын төмөр замын ашиглалтын ажлын үндсэн үзүүлэлтийн мэдээлэл дээр үндэслэсэн болно.



E-NEWSLETTER

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САМБАР

Зургаадугаар сар 2017 он



САЛБАРЫН МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ, СУНГАХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БАЙНА



Төмөр замын салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх ажлыг төлөвлөж, зохион байгуулах зорилтын хүрээнд териин бус байгууллагуудтай хамтран төмөр замын тээврийн салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах сургалт зохион байгууллаа. Сургалтад 13 зэрэг горилогчид хамрагдаж амжилттай дүүргэн гэрчилгээ, тамгаа гардан авлаа.

ТӨВИЙН МЭРГЭЖИЛТНҮҮД БНХАУ-ААС ЗОХИОН БАЙГУУЛЖ БҮЙ ЭЭЛЖИТ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА

БНХАУ-ын Худалдааны яам, Олон улсын худалдаа бизнесийн академи, Зүүн Өмнөдийн Зам, харилцааны их сургуулиас Сы Чуань мужийн Чэнь Дү хотноо зохион байгуулагдаж буй хөгжиж буй улс орнуудад зориулсан “Цахилгаанжуулсан төмөр замын эрчим хүч хангамжийн технологи” сэдэвт сургалтад төвийн мэргэжилтнүүд хамрагдлаа. Энэ удаагийн сургалт нь лекц, семинар, кейс судалгаа, техник, технологитой танилцах, практик дадлага зэрэг төрлөөр явагдсан. Мөн Хятадын өнөөгийн нөхцөл байдал, цахилгаанжуулсан төмөр замын эрчим хүч хангамжийн систем, эрчим хүч хангамжийн системийн шинжилгээ, зураг төсөл, цахилгаанжсан төмөр замын реле хамгаалалт, дэд станцын автомат технологи гэсэн агуулгатай. Сургалтад хамрагдах мэргэжилтнүүд БНХАУ-ын томоохон үйлдвэр, компаниудаар зочилж, мэргэжлийн хүмүүстэй санал солилцож, Хятадын эдийн засаг, хөгжлийн талаар тодорхой ойлголттой болж, хамтран ажиллах боломж бүрдэх юм.





E-NEWSLETTER

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САМБАР

Зургаадугаар сар 2017 он

МЭДЭЭЛЛИЙН ЦАГААР ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



“Цахим гарын үсэг”-ийг хэрхэн хэрэглэх талаар ажилтнуудад мэдээлэл өглөө

Технологи, мэдээлэл сургалт, судалгааны хэлтсээс зохион байгуулсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам” мөрдөгдөж эхлэхтэй холбогдуулан “Цахим гарын үсэг”-ийг хэрхэн хэрэглэх үйл ажиллагаандaa яаж мөрдөх талаар 06 дугаар сарын 12-ны өдөр нийт ажилтнуудад сургалт, мэдээллийг өгсөн.

“Ажилтны ёс зүй болон хувь хүний нууцын тухай хууль” сэдвээр төвийн ажилтнуудад мэдээлэл хийв

Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний хавсралт болох төвийн үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөөний манлайллын зорилтын нэгдүгээр зорилтын хүрээнд “Ажилтны ёс зүй болон хувь хүний нууцын тухай хууль” сэдвээр төвийн ажилтнуудад мэдлэг, мэдээлэл өгөх сургалтыг 06 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан.



Эрүүл биеед саруул ухаан оршино

Аюулгүй таатай орчинд ажиллах нь эрүүл, сайн сайхан амьдралын гол үндэс юм. Ажлын байранд хийх дасгал нь ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, хөдөлмөрийн явцад бий болсон ядралыг сэргээх, ажлын чадварыг нэмэгдүүлэн улмаар хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх ач холбогдолтой. Тиймээс Төвийн мэргэжилтнүүд ажлын байран дахь дасгал хөдөлгөөнийг дэмжих зорилгоор өдөр тутам тогтмол цагт дасгал хөдөлгөөн хийн хэвшиж байна.





E-NEWSLETTER

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САМБАР

Зургаадугаар сар 2017 он

БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ХОГГҮЙ ОРЧИН БИЙ БОЛГОЁ

Төвийн хамт олон “Бүтээлч ажлын төлөвлөгөө”-ны хүрээнд 2017 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Байгаль орчинд ээлтэй хоггүй орчин бий болгох цэвэрлэгээний ажил зохион байгуулж Яармагийн гүүрний баруун хэсгийн Туул голын эрэг дагуух хог хаягдлыг цэвэрлэн багахан ч болов хувь нэмэр орууллаа. Урин дулаан цаг ирж иргэд нийслэл орчмын голын ай сав газрыг бохирдуулах нь ихсэх болсонтой холбогдуулан иргэдийг аялал зугаалгад явахдаа хог хаягдлаа авч явах, зориулалтын цэгт хаяж байхыг уриалж байна.



ХОЛБОО БАРИХ



Утас: +976 77244403



Факс: +976 7724 4403



Веб: rtcc.mrtd.gov.mn

https://twitter.com/rtcc_mn



<https://www.facebook./rtcc.mon/>

И-мэйл: info@rtcc.mrtd.gov.mn



Хаяг: “Хан-Уул“ цамхаг,



Б.Шаравын гудамж 6, 3-р хороо,

Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс